



Гадаад паспортын вйлчилгээг товийн 6 дvvрэг рvv шилжvvлэхээр болсон талаар Оюуны омч, улсын бүртгэлийн еронхий газраас хэвлэл бага хурал хийлээ. Хуралд ООУБЕГ-ын дэд дарга Д.Дэлгэрсайхан, Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Иргэний бүртгэлийн газрын дарга Д.Энхцэцэг, Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нар оролцлоо.

Оюуны омч, улсын бүртгэлийн еронхий газар нь нэг цэгт товлорч байсан гадаад паспортын вйлчилгээг сааруулж, 10 цэгээр дамжуулан иргэдэд вйлчлэхээр ажиллаж байна. Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн вйлчилгээний ачааллыг бууруулах, товлорлийг сааруулах, торийн вйлчилгээг шуурхай хvргэх зорилгоор 2018 оны 04 сарын 09-ний одроос эхлэн Баянгол, Сvxбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзvрх дvvргийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн вйлчилгээний нэгдсэн 4 товд гадаад паспортын энгийн, яаралтай вйлчилгээг шилжvvлэхээр боллоо. Оороор хэлбэл, иргэд харьяалал харгалзахгvйгээр товийн 6 дvvрэг, нийслэлийн вйлчилгээний нэгдсэн товvдийн улсын бүртгэлийн хэлтсээс гадаад паспортын вйлчилгээг авдаг болох юм. Харин Зуун айлд байрлах вйлчилгээний 1 дvгээр байранд гадаад паспортын вйлчилгээ взvvлэхгvй.

Улсын бүртгэлийн байгууллага нь 2015 онд 286862, 2016 онд 298464, 2017 онд 350421, 2018 оны 03 сарын 15-ны одрийн байдлаар 70489 иргэнд гадаадад зорчих эрхийн бүртгэлийн вйлчилгээ үзүүлээ.